

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: Buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Г.Даваасүрэн
Утас: 70359826 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.25 № 82
танай _____-ны № _____-т

Г ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫНГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ГАНЗОРИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Засгийн газрын “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 2024 оны 166 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын хэрэг эрхлэх газраас “Шинэ хоршоо хөдөлгөөн” хойд бүсийн арга хэмжээг зохион байгуулахад 204,065.4 мянган төгрөгийн санжүүжилт хүлээн авч, орон нутагтаа амжилтай зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын А/02 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог 7 хэлтэс 54 албан хаагчтай, 2024 оны 01 дүгээр сарын А/03 дугаар тушаалаар аймгийн Засаг дарга Тамгын газрын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний албан тушаалын орон тоог 15 албан хаагчтай нийт 67 албан хаагчтай байхаар баталжээ.

Бусад асуудал

Тайлант онд Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг даргын захирамжуудаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нарыг сэлгүүлэн ажиллуулахаар томилсон байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,177,208,909.00</u>	<u>1,741,834,228.00</u>	
35	БАРАА МАТЕРИАЛ	1,177,208,909.00	1,741,834,228.00	
351	Түүхий эд материал	319,430,160.00	445,416,370.00	
35110	Тусгай зориулалттай материал	319,430,160.00	445,416,370.00	
354	Хангамжийн материал	857,778,749.00	1,296,417,858.00	
35410	Бичиг хэргийн материал	4,045,700.00	2,170,700.00	
35420	Аж ахуйн материал	36,552,620.00	57,022,440.00	
35430	Сэлбэг хэрэгсэл	27,994,000.00	44,554,000.00	
35450	Барилгын засварын материал	720,661,629.00	1,127,145,918.00	
35470	Бусад хангамжийн материал	68,524,800.00	65,524,800.00	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,899,715,029.01</u>	<u>10,559,539,410.71</u>	
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,899,715,029.01	10,559,539,410.71	
392	Биет хөрөнгө	8,422,616,647.42	8,066,612,167.85	
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,107,165,400.00	6,159,535,400.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	(368,047,726.15)	(488,368,655.99)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	919,822,719.70	872,038,444.00	
39204	Хуримтлагдсан элэгдэл	(644,851,811.82)	(571,802,583.08)	
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,779,436,680.57	2,883,683,670.57	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(876,003,852.74)	(1,244,462,609.58)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	870,268,941.30	775,767,810.30	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(411,072,015.10)	(357,346,850.43)	
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,488,243.48	63,488,243.48	
39215	Хуримтлагдсан элэгдэл	(17,589,931.82)	(25,920,701.42)	
393	Биет бус хөрөнгө	2,477,098,381.59	2,492,927,242.86	
39301	Програм хангамж	339,708,087.00	477,488,087.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(148,929,705.41)	(270,880,844.14)	
39303	Бусад биет бус хөрөнгө	2,286,320,000.00	2,286,320,000.00	
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>12,076,923,938.01</u>	<u>12,301,373,638.71</u>	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7,180,000.00</u>	-	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,180,000.00	-	
413	Өглөг	7,180,000.00	-	
4136	Бусад өглөг	7,180,000.00	-	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,180,000.00	-	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>12,076,923,938.01</u>	<u>12,301,373,638.71</u>	
51	Засгийн газрын хувь оролцоо	12,076,923,938.01	12,301,373,638.71	
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,396,883,998.91	4,396,883,998.91	
512	Хуримтлагдсан үр дүн	5,553,305,765.31	5,784,935,466.01	
51210	Өмнөх үеийн үр дүн	5,553,305,765.31	5,553,305,765.31	
51220	Тайлант үеийн үр дүн	-	231,629,700.70	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,119,554,173.79	2,119,554,173.79	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>12,076,923,938.01</u>	<u>12,301,373,638.71</u>	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,550,344,985.62	7,623,410,464.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,361,047,718.62	939,640,329.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,361,047,718.62	939,640,329.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,361,047,718.62	939,640,329.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,024,978.00	9,131,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,351,022,740.62	930,508,629.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,189,297,267.00	6,683,770,135.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	224,936,467.00	530,200,235.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,107,969.00	224,065,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,135,796.00	153,667,435.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,692,702.00	152,467,200.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,964,360,800.00	6,153,569,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,964,360,800.00	6,153,569,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,008,735,201.39	7,325,177,438.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,008,735,201.39	7,325,177,438.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,347,741,768.83	5,577,693,525.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,177,752,160.98	2,793,170,936.18
210101	Үндсэн цалин	1,113,574,308.58	1,390,692,059.18
210102	Нэмэгдэл	689,931,671.40	968,951,857.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	244,984,372.00	252,662,365.00
210104	Урамшуулал	129,261,809.00	180,864,655.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,784,876.69	330,109,501.61
210201	Тэтгэврийн даатгал	166,450,076.69	229,545,211.90
210202	Тэтгэмжийн даатгал	21,333,700.00	24,075,619.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,067,000.00	14,850,182.55
210204	Ажилгүйдлийн даатгал	4,266,700.00	6,628,684.18
210205	Эрүүл мэндийн даатгал	42,667,400.00	55,009,803.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,381,733.49	107,377,595.68
210301	Гэрэл, цахилгаан	37,348,955.32	52,732,236.25
210302	Түлш, халаалт	37,090,064.46	41,875,445.51
210303	Цэвэр, бохир ус	14,942,713.71	12,769,913.92
2104	Хангамж, бараа материалын зардал	186,769,564.78	234,292,631.73
210401	Бичиг хэрэг	71,765,100.00	80,520,850.00
210402	Тээвэр, шатахуун	45,709,344.00	67,867,654.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,655,395.78	20,124,787.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	38,575,875.00	36,155,340.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,063,850.00	29,624,000.00
2105	Нормативт зардал	42,535,016.00	13,751,730.00
210502	Хоол, хүнс	42,535,016.00	13,751,730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,330,017.00	132,281,330.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	146,160,400.00	11,000,000.00
210602	Тавилга	7,650,000.00	-
210604	Урсгал засвар	96,519,617.00	121,281,330.00
2107	Томилолт, зочны зардал	44,731,968.00	92,138,700.00
210702	Дотоод албан томилолт	44,731,968.00	92,138,700.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	173,884,321.50	326,459,503.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,458,400.00	264,144,214.00
210803	Даатгалын үйлчилгээ	15,717,000.00	13,401,646.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,237,458.00	1,016,542.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,230,700.00	33,178,151.00
210807	Газрын төлбөр	15,196,763.50	14,410,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,130,572,110.39	1,548,111,596.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	356,791,146.40	607,628,788.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	12,359,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	773,780,963.99	928,123,008.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	660,993,432.56	1,747,483,913.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,402,500.00	487,658,721.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,269,200.00	28,681,140.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	217,032,381.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,133,300.00	241,945,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	520,590,932.56	1,259,825,192.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	520,590,932.56	1,259,825,192.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	4,541,609,784.23	298,233,025.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	88,641,206.58	66,603,324.91
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	88,641,206.58	66,603,324.91
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(88,641,206.58)	(66,603,324.91)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	4,452,968,577.65	231,629,700.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,399,322,245.00	6,692,901,835.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,024,978.00	9,131,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,024,978.00	9,131,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,024,978.00	9,131,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,024,978.00	9,131,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,389,297,267.00	6,683,770,135.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	424,936,467.00	530,200,235.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	248,107,969.00	224,065,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,135,796.00	153,667,435.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	134,692,702.00	152,467,200.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,964,360,800.00	6,153,569,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,964,360,800.00	6,153,569,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,268,137,445.00	6,479,616,435.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,268,137,445.00	6,479,616,435.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,605,620,092.44	4,708,128,121.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,177,752,160.98	2,793,170,936.18
210101	Үндсэн цалин	1,113,574,308.58	1,390,692,059.18
210102	Нэмэгдэл	689,931,671.40	968,951,857.00

210103	Унаа хоолны хөнгөлөлт	244,984,372.00	252,662,365.00
210104	Урамшуулал	129,261,809.00	180,864,655.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	251,784,876.69	330,109,501.61
210201	Тэтгэврийн даатгал	166,450,076.69	229,545,211.90
210202	Тэтгэмжийн даатгал	21,333,700.00	24,075,619.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,067,000.00	14,850,182.55
210204	Ажилгүйдлийн даатгал	4,266,700.00	6,628,684.18
210205	Эрүүл мэндийн даатгал	42,667,400.00	55,009,803.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,381,733.49	107,377,595.68
210301	Гэрэл, цахилгаан	37,348,955.32	52,732,236.25
210302	Түлш, халаалт	37,090,064.46	41,875,445.51
210303	Цэвэр, бохир ус	14,942,713.71	12,769,913.92
2104	Хангамж, бараа материалын зардал	198,422,111.78	267,735,086.73
210401	Бичиг хэрэг	65,723,900.00	65,067,250.00
210402	Тээвэр, шатахуун	40,974,594.00	67,384,479.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,655,395.78	20,439,787.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	43,369,875.00	60,386,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,698,347.00	54,456,870.00
2105	Нормативт зардал	24,140,000.00	135,360,000.00
210502	Хоол, хүнс	6,300,000.00	108,420,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,840,000.00	26,940,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	288,492,424.00	187,859,640.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	165,073,300.00	27,359,600.00
210602	Тавилга	7,650,000.00	259,000.00
210604	Урсгал засвар	115,769,124.00	160,241,040.00
2107	Томилолт, зочны зардал	44,731,968.00	92,138,700.00
210702	Дотоод албан томилолт	44,731,968.00	92,138,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,359,421.50	387,212,783.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,278,400.00	308,062,744.00
210803	Даатгалын үйлчилгээ	15,717,000.00	13,401,646.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,237,458.00	1,016,542.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	308,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,885,800.00	50,012,901.00
210807	Газрын төлбөр	15,196,763.50	14,410,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	352,555,396.00	407,163,878.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	352,555,396.00	388,304,078.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	18,859,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	662,517,352.56	1,771,488,313.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,926,420.00	511,663,121.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,269,200.00	28,681,140.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	217,032,381.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	116,657,220.00	265,949,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	520,590,932.56	1,259,825,192.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	520,590,932.56	1,259,825,192.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	131,184,800.00	213,285,400.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	131,184,800.00	213,285,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	131,184,800.00	213,285,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	131,184,800.00	213,285,400.00
220001	Барилга байгууламж		52,370,000.00

222001	Тоног төхөөрөмж	91,279,300.00	141,797,600.00
223001	Бусад хөрөнгө	39,905,500.00	19,117,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(131,184,800.00)</u>	<u>(213,285,400.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,396,883,998.91	2,119,554,173.79	5,553,305,765.31	12,069,743,938.01
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,396,883,998.91	2,119,554,173.79	5,553,305,765.31	12,069,743,938.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,396,883,998.91	2,119,554,173.79	5,553,305,765.31	12,069,743,938.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	231,629,700.70	231,629,700.70
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,396,883,998.91	2,119,554,173.79	5,784,935,466.01	12,301,373,638.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,161,569,900.00	4,904,785,797.70	1,256,784,102.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,161,569,900.00	4,904,785,797.70	1,256,784,102.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,644,549,100.00	4,395,102,676.70	1,249,446,423.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,408,637,300.00	2,761,670,377.18	646,966,922.82
210101	Үндсэн цалин	1,532,891,100.00	1,359,191,500.18	173,699,599.82
210102	Нэмэгдэл	1,365,051,200.00	968,951,857.00	396,099,343.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	315,992,400.00	252,662,365.00	63,330,035.00
210104	Урамшуулал	194,702,600.00	180,864,655.00	13,837,945.00
210105	Гэрээт ажлын хөлс			-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	415,292,900.00	326,072,309.61	89,220,590.39
210201	Тэтгэврийн даатгал	282,399,300.00	225,508,019.90	56,891,280.10
210202	Тэтгэмжийн даатгал	33,223,000.00	24,075,619.46	9,147,380.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,290,100.00	14,850,182.55	10,439,917.45
210204	Ажилгүйдлийн даатгал	10,510,500.00	6,628,684.18	3,881,815.82
210205	Эрүүл мэндийн даатгал	63,870,000.00	55,009,803.52	8,860,196.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	179,788,000.00	107,377,595.68	72,410,404.32
210301	Гэрэл, цахилгаан	62,727,000.00	52,732,236.25	9,994,763.75
210302	Түлш, халаалт	80,230,100.00	41,875,445.51	38,354,654.49
210303	Цэвэр, бохир ус	36,830,900.00	12,769,913.92	24,060,986.08

210304	Байрны түрээс			-
2104	Хангамж, бараа материалын зардал	304,100,900.00	254,122,886.73	49,978,013.27
210401	Бичиг хэрэг	62,167,600.00	62,167,250.00	350.00
210402	Тээвэр, шатахуун	104,212,000.00	56,993,779.00	47,218,221.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,636,800.00	20,439,787.73	2,197,012.27
210404	Ном, хэвлэл			-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,870,000.00	60,386,700.00	483,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,214,500.00	54,135,370.00	79,130.00
2105	Нормативт зардал	30,000,000.00	22,890,000.00	7,110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	30,000,000.00	22,890,000.00	7,110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	286,734,000.00	283,213,440.00	3,520,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	123,025,000.00	119,667,400.00	3,357,600.00
210602	Тавилга	11,900,000.00	11,876,800.00	23,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			-
210604	Урсгал засвар	151,809,000.00	151,669,240.00	139,760.00
2107	Томилолт, зочны зардал	96,512,000.00	81,726,700.00	14,785,300.00
210701	Гадаад албан томилолт			-
210702	Дотоод албан томилолт	96,512,000.00	81,726,700.00	14,785,300.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	268,984,000.00	215,539,889.50	53,444,110.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,020,000.00	125,529,950.00	3,490,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,752,000.00	-	1,752,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	13,417,000.00	13,401,646.00	15,354.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,450,000.00	1,016,542.50	433,457.50
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	425,000.00	308,000.00	117,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,900,000.00	60,872,801.00	28,027,199.00
210807	Газрын төлбөр	34,020,000.00	14,410,950.00	19,609,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	654,500,000.00	342,489,478.00	312,010,522.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	634,500,000.00	323,629,678.00	310,870,322.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,000,000.00	18,859,800.00	1,140,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	517,020,800.00	509,683,121.00	7,337,679.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	517,020,800.00	509,683,121.00	7,337,679.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,431,400.00	28,681,140.00	2,750,260.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	221,078,900.00	217,032,381.00	4,046,519.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	264,510,500.00	263,969,600.00	540,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,904,785,797.70	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	4,895,654,097.70	
132001	Орон нутгийн төсвөөс	-	4,895,654,097.70	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	9,131,700.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	9,131,700.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	
610001	Төсвийн байгууллага	1	1	
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/ Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,290,845.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,290,845.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	526,310,845.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,500,559.00
210101	Үндсэн цалин	31,500,559.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,037,192.00
210201	Тэтгэврийн даатгал	4,037,192.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,612,200.00
210401	Бичиг хэрэг	2,900,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,390,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	321,500.00
2105	Нормативт зардал	112,470,000.00
210502	Хоол, хүнс	108,420,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,050,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,621,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	88,549,900.00
210602	Тавилга	3,200,000.00
210604	Урсгал засвар	12,871,800.00
2107	Томилолт, зочны зардал	10,412,000.00
210702	Дотоод албан томилолт	10,412,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	182,532,794.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,532,794.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,124,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,124,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,980,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,980,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,980,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	530,200,235.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	530,200,235.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	224,065,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	153,667,435.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	152,467,200.00
131106	Төсвийн урамшуулал	
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт: Залруулсан алдаа:

Аудитаар залруулсан алдаа¹ гараагүй болно.

Аудитаар нийт 40,336.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 980.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 39,356.4 мянган төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 3 зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Тайлант оны 12 сард цалинтай чөлөөтэй байсан нэг албан хаагчид 440.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон, томилолтын 540.0 мянган төгрөгийн зардал илүү олгосон зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид байгууллагын дотоод журмын дагуу 1,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон, тайлант оны 12 сард баримтын анхан шатны бүрдлийн шаардлага хангаагүй томилолтын хуудсаар 8,100.0 мянган төгрөгийн томилолтыг 6 албан хаагчид тооцон олгосон, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэхээс зайлсхийж, 344,555.0 мянган төгрөгийн 27 төлбөр тооцооны зарлагыг зориудаар 5 саяас доош үнийн дүнтэй 87 төлбөрийн хүсэлтээр зардлын гүйлгээг хийсэн, Засаг даргын нөөц сангаас 10,844.4 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэн тараасан, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал 19,142.0 мянган төгрөгийг ариутгал халдваргүйжүүлэлт хийх тусгай эрхгүй оёдлын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлсэн зөрчлүүдэд 5 албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Нүүрээр таних цагийн бүртгэлийн системээр 5940 цаг дутуу бүртгүүлсэн тамгын газрын хэлтэс, албадын 7 даргад цалинг бүтэн бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цагийн бүртгэлийн системийн бүртгэлийг үндэслэн цалин олгох.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс зочид буудал, хоолны зардалд 39,786.3 мянган төгрөг, тэмцээний зардалд 18,604.5 мянган төгрөг, түрээсийн зардалд 16,800.0 мянган

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөг, бусад төрийн байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээнд 62,174.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно.", 2.1-д "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна:", 2.1.1-д "хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;", 2.1.2-д "үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;", 2.1.3-д "тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;", 2.1.4-д "байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх;", 2.1.5-д "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ;", 2.1.6-д "шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг." гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг журамд заасан арга хэмжээнд зарцуулах

3. Бүтэц орон тоотой холбоотой

Илрүүлэлт: Аймгийн Засаг даргын тамгын газрын орон тоо нь Засгийн газрын тогтоолоор баталсан орон тооны хязгаараас 10 албан хаагчаар хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.2-д "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;", Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.2-д "Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газраас нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтоох бөгөөд нийслэлийн Засаг даргын тамгын газар нь газар, хэлтэс, тасагтай, аймаг, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь хэлтэс, тасагтай байна.", Засгийн газрын 377 дугаартай "Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" тогтоолын 3-д "Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 57 хүртэл, Булган, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрыг 55 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 41 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай." Төрийн албаны тухай хуулийн 39.1-д "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:", 39.1.3-д "хуульд нийцээгүй шийдвэр гаргах;" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарт багтан ажиллах.

4. Төсвийн, төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын 2024 оны төсвийн төслийг тооцоо судалгаагүй хэт өндөр дүнгээр төсөвлөснөөс шалтгаалан төсвийн гүйцэтгэл 20.4 хувь буюу 1,256,784.1 мянган төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2-д "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх;" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын	11	40,336.4	2	980.0	5	39,356.4	3	0				
Дүн	11	40,336.4	2	980.0	5	39,356.4	3	0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			